



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 8 сарын 29 өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

Үнэт цаасыг нийтэд санал болгохыг  
зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 6.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Зоос гоёл” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 13,038 /арван гурван мянга гучин найман/ ширхэг энгийн хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

2. Хувьцаагаа компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгийг нэгж хувьцаанд 289,440 /хоёр зуун наян есөн мянга дөрвөн зуун дөч/ төгрөгөөр тооцон “ҮЦТХТ” ХХК-д гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцөлөөр хангахыг “Зоос гоёл” ХК /Д.Нарангэрэл/, “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д тус тус үүрэг болгосугай.

3. Компанийн хэлбэрийг өөрчлөн хязгаарлагдмал хариуцлагатай компани болох шийдвэр гарсантай холбогдуулан өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүнд ногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг дурдсугай.

4. Энэ тогтоолын 3-т заасан хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчийг өөрчлөн байгуулагдаж байгаа хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчээр бүртгэж авах үүргийг тухай бүр хэрэгжүүлэхийг “Зоос гоёл” ХК /Д.Нарангэрэл/-д даалгасугай.

5. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА

С.ДАВААСҮРЭН



E:\ajil 2018\Blank\Togtool.doc

000632